



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 01 сарын 03-ны
өдрийн 6534 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А1261

Улаанбаатар хот

Тендер шалгаруулалтын жишиг
баримт бичиг шинэчлэн батлах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 11 дүгээр зүйлийн 11.14, 55 дугаар зүйлийн 55.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг"-ийг нэгдүгээр, "Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг"-ийг хоёрдугаар, "Харьцуулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг"-ийг гуравдугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Ганбат), Хууль, эрх зүйн газар (З.Энхболд)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Тендерийн жишиг баримт бичиг батлах тухай" Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тушаалыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



Б.ЖАВХЛАН

САНГИЙН ЯАМНЫ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Бүртгэлийн №. 211
Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
Архивын эрхлэгч
Хугацаа: 105 хуудас 2023 он 12 сар 25 өдөр

9763000849